

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ

23 ДУГААР СУРГУУЛЬ



ХИМИЙН БАГШ М.НАМЖИЛМААГИЙН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН
ХИМИЙН БАГШ МӨНХБАЯР ОВОГТОЙ НАМЖИЛМААГИЙН 2018-2019 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

I. Төлөвшил

ЗОРИЛГО:

Химийн судлагдахууны зорилтын хүрээнд суралцагчийн шинжлэх ухаан арга барил болон суралцах арга барилыг хөгжүүлэн, ээлжит хичээл бүрийг үр өгөөжтэй бэлтгэлтэй зааж, суралцагчийн үнэлгээнд анализ хийн, багшлах арга барилаа хөгжүүлэхэд оршино.

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

- 2019 оны 02 сарын 27-28 өдрүүдэд "MOODLE, КОНА" систем танилцуулах үйл ажиллагаанд зохион байгуулалтанд ажиллав.
- 2019 оны 03 сарын 9 өдөр Нийслэлийн ХУД-ийн 52 сургууль дээр химийн олимпиадын засалтанд оролцов.
- 2019 оны 03 сарын 16 өдөр Чингэлтэй дүүргийн Газарзүйн олимпиадын зохион байгуулалтын ажилд тусалсан.
- 2019 оны 03 сарын 21 өдөр "Гамшгийн дуут дохио" ажиллав.
- 2019 оны 04 сарын 10-11 өдрүүдэд Нийслэлийн мэдээлэл зүйн олимпиадын бэлтгэл ажилд тусалж хянагч багшаар ажиллав.
- 2019 оны 04 сарын 26 "Хүүхдийг зодож шийтгэдэггүй өдөр" Чингисийн талбай жагсаалд оролцов.
- 2019 оны 05 сарын 15 - 16 өдрүүдэд 14:30 – 18:00 цагийн хооронд "Улаан бурхан, улаанууд" өвчнөөс сэргийлэх вакцинд хамрагдаж буй сурагчдын бүртгэлийн ажил хийв.
- Гацуурт - Хүрэн толгойн чиглэлийн явган аялалд оролцож эрүүл мэнддээ анхаарч чөлөөт цагаа зөв сайхан өнгөрүүлсэн.
- 2019 оны 04 сарын 20 өдөр "Бүх нийтийн хаврын цэвэрлэгээ 90 минут" сургуулийн үүдний талбайн хэсэг , 2 талын хашааг угааж цэвэрлэсэн.
- Гадаад хэлний баярын үеэр Герман хэлний самбарын эх бэлтгэж самбарын чимэглэл хийж, солонгос хэлний тоглолтын тайзны ард бэлтгэл ажилд тусалсан.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал

- Хичээл орох дэг, жижүүр анги хийх дэг, шалгалт өгөх дэгүүдийг дунд ангийн сурагчдын хувьд мэндлэх хүндлэх ёс, ангийн ариун цэвэр, агааржуулалт мөн нийт сурагчдын хувьд усны зөв зохистой хэрэглээ, хогоо ангилан ялгаж хаяхыг хэвшүүлэх тал дээр илүү ажилласан.

3. Бусадтай харилцах зан чанар

- Сургуулийн удирдлага, мэргэжлийн багш нар болон суралцагчидтай харилцааны ямар нэгэн доголдол гаргаагүй болно. Багшийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.

4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал

- Чингэлтэй дүүргийн химийн олимпиадад 9-р ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулж, 9в ангийн сурагч Б. Оюуномин 4-р байранд орж хүрэл медаль авав.
- "Эртэч хүүхэд-2" аяны хүрээнд 9в,9г,9е ангийн нийт 114 сурагчдад улсын шалгалтын даалгаврын сан болон жишиг даалгавраар 5 удаагийн давтлага, Байгалийн ухааны судалгахуунаар шалгалт өгөх 9-р ангийн бүх бүлгийн сурагчдад 2 удаагийн давтлага өгсөн.

5. Жижүүр багшийн үнэлгээ

- 2019 оны 2 сарын 25 өдрийн үдээс хойш 13 цаг 10 минутаас 19 цаг 30 минут хүртэл жижүүр багшийн үүргийг нийгмийн ажилтан С. Оюунцэцэг хамт хийж 24 оноотой гүйцэтгэсэн.
- 2019 оны 3 сарын 07 өдрийн үдээс хойш 13 цаг 10 минутаас 19 цаг 30 минут хүртэл жижүүр багшийн үүргийг бага боловсролын сургалтын менежер З. Тунгалаг хамт хийж 30 оноотой гүйцэтгэсэн.
- 2019 оны 4 сарын 04 өдрийн үдээс хойш 13 цаг 10 минутаас 19 цаг 30 минут хүртэл жижүүр багшийн үүргийг бага боловсролын сургалтын менежер З. Тунгалаг хамт хийж 30 оноотой гүйцэтгэсэн.
- 2019 оны 5 сарын 14 өдрийн үдээс хойш 13 цаг 10 минутаас 19 цаг 30 минут хүртэл жижүүр багшийн үүргийг суурь боловсролын сургалтын менежер М. Цогзолмаа хамт хийж 30 оноотой гүйцэтгэсэн.
Тухайн өдрийн сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж өнгөрсөн.

6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал

- 9в, 9г, 9е ангийн сурагчдаас "Сурах хэв шинж" - ийн 30 асуулга бүхий судалгааг авч үр дүнг нэгтгэж, судалгааны үр дүнгээ хичээл сургалтын үйл ажиллагаандаа тусган ажиллаа.
- Судалгаанд нийт 129 сурагч оролцож нийт сурагчдын 80% нь холимог сурах хэв шинжтэй гарсан нь сонсох, харах, хийх, бүтээх гэсэн 4 төрлийн хэв шинжээр суралцдаг болох нь харагдсан. Иймд сурагчдаар бүтээл хийлгэх, эссэ бичүүлэх, персентац хийлгэх, бодлого бодуулах гэх мэт аргаар хичээлээ бэлтгэн заасан.

7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

- 2019 оны 3 сарын 21 өдөр 20:00-21:30 цагийн хооронд 6в, 6е ангийн сурагчдын 15 эцэг эхтэй уулзаж сурагчдын талаар харилцан ярилцаж шинжлэх ухаанч арга барилын тухай зөвлөн тусалсан..

- 2019 оны 3 сарын 22 өдөр 20:00-22:00 цагийн хооронд 8в, 8д ангийн сурагчдын 13 эцэг эхтэй уулзаж сурагчдын талаар харилцан ярилцаж зөвлөн тусалсан.
- 2019 оны 3 сарын 26 өдөр 20:00-21:00 цагийн хооронд 11в, 11д ангийн сурагчдын 15 эцэг эхтэй уулзаж сурагчдын мэдлэг, чадвар цаашид анхаарах зүйлсийн талаар харилцан ярилцсан.
- 2019 оны 3 сарын 27 өдөр 20:00-21:30 цагийн хооронд 10в, 10г, 10д ангийн сурагчдын 14 эцэг эхтэй уулзаж сурагчдын талаар харилцан ярилцаж цаашид анхаарах зүйлсийг тухай зөвлөн тусалсан.
- 2019 оны 3 сарын 28 өдөр 20:00-22:30 цагийн хооронд 9в, 9г, 9е ангийн нийт сурагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварын жагсаалт гарган сурагч нэг бүрийг дүгнэн эцэг эхэд танилцуулж улсын шалгалтын тухай зөвлөн тусалсан.

8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт

- Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг ажилдаа орсон цагаасаа мөрдөн ажиллаж зөрчил дутагдал гаргаагүй.

9. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт

- Зөв зан чанар , хандлагатай , бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд чиглүүлэн өөрийгөө илэрхийлэх , анги хамт олноор хамтран ажиллах , хүүхэд нэг бүрийн хөгжилд дэм өгөхүйц хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан.

II. Мэдлэг чадвар ахиц, амжилт

- Гарааны болон Оношлох үнэлгээ
8 ангийн сурагчдаас мэдлэг чадварын сорилын шалгалт авсан.
- 9в, 9г, 9е ангийн нийт 31 сурагч Байгалийн ухааны хичээлийг сонгон шалгалт өгсөн.

1. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/

- 2018 - 2019 оны хичээлийн жилийн III улирлаас эхлэн 6, 8, 9, 10, 11 - р ангид химийн хичээлийг орсон.

III улирал

6 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \10 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Хүчиллэг ба суурилаг шинж" – 6 цаг , "Саармагжих үзэгдэл " – 4 цаг

8 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Халах урвал ба идэвхийн эгнээ" – 11 цаг, "Урвалын хурд түүнд нөлөөлөх хүчин зүйлс " – 7 цаг

9 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Химийн энерги" – 10 цаг, "Хүчил , суурь ба давс " – 8 цаг

10 - р ангийн 1 нэгж "Органик биш хими" \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

11-р анги 2 нэгж хичээлийн төлөвлөлт \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Үелэх хүснэрт, үелэх хандлага"-10 цаг, "Химийн бодисын үйлдвэрлэл, хэрэглээ"- 8 цаг

IV улирал

6 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \18 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Хими ба амьдрал " – 9 цаг

8 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Химийн энерги" – 6 цаг, "Судлаачдын мөрөөр " – 12 цаг

9 - р ангийн 2 нэгж хичээлийн төлөвлөлт \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

"Органик нэгдэл" – 10 цаг, "Агаар ба ус" – 8 цаг

10 - р ангийн 1 нэгж "Органик хими" – 16 цаг \16 ээлжит хичээлийн төлөвлөлт\

Стандарт хэрэгжилт

- 6в, 6е, 8в, 8д, 9в, 9г, 9е, 10в, 10г, 10д, 11в, 11д нийт 12 бүлгийн 582 сурагчид III, IV улиралд 16 нэгж хичээл, 162 цагийн ээлжит хичээлийг заасан. Хичээлийн жилийн IV улиралд 11д ангид "Эрүүл мэнд"-ийн хичээлийг 9 цаг заасан байна.

2. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

- Багшлах стратегийн хувьд – Суурь болон бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр мөн MOODLE цахим системийг хичээл сургалтандаа ашигласан.
- Суралцах стратегийн хувьд – 5 дахь жилийн "Багшлах эрхийн үндсэн сургалт" – д хамрагдан амжилттай 93% дүнтэй суралцсан. Мөн MOODLE цахим системийн сургалтанд 4 удаа хамрагдан 90% дүнтэй шалгагдан сертификат авсан.
- Мэргэжлийн чадварын хувьд – Чингэлтэй дүүргийн химийн багш нарын эрхлэн гаргаж байгаа "Экологийн агуулгатай 100 бодлого" химийн секцийнхээ багш нартай хамтран бодож бодолтын хамт шивж явуулсан.
- Сургалтын орчин хэрэглэгдэхүүн - 6, 8, 9, 10, 11 ангид нийт 34 цахим хичээл бэлтгэн заасан.
- Хичээлийн онцлог – Сурагчдын байгалийн юмс, үзэгдлийг танин мэдэх арга барилыг хөгжүүлж, таамаглал дэвшүүлэх, зорилготойгоор ажиглалт, туршилт хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулах, бусдад илэрхийлэхэд суралцуулж байна. Орчин үеийн техник, технологийн мэдлэг, чадвараа хэрэглэж, байгалийн ухааны хэл эзэмшүүлэхийг зорьж ажилласан. Мөн MOODLE цахим системийн давуу талыг ашиглан сурагчдаар бие даалт хийлгэх, туршилтын бичлэг үзүүлж мэдлэг бүтээх зэрэг онцлогтой байсан.

3. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн

- 6в, 6е, 8в, 8д, 9в, 9г, 9е, 10в, 10г, 10д, 11в, 11д нийт 12 бүлгийн 582 сурагчид III, IV улиралд 16 нэгж хичээл, 162 цагийн ээлжит хичээлийг заасан. Хичээлийн жилийн IV улиралд 11д ангид "Эрүүл мэнд"-ийн хичээлийг 9 цаг заасан байна.

4. Журнал бичилт

- Ерөнхий Боловсролын Сургуулийн III-XII ангийн багшийн журнал хөтлөх зааврын дагуу хөтөлсөн. Багшийн журнал хөтлөлтийг сургалтын менежерийн өгсөн зөвлөгөөний дагуу хөтөлж, цаг тухай бүрт нь шалгуулж байсан.

5. Хичээл ордог сурагчдын хүртээмж

- 6, 8, 9,10,11 ангийн нийт 12 бүлгийн 582 сурагчид химийн хичээлийг өдөрт 5-6 цаг зааж байна. Хичээл болгон дээр гэрийн даалгавар шалгах, дэвтрийн үйл ажиллагааг тогтмол шалгахыг хичээсэн.

6. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт

- Багшийн хөгжлийн дэвтрийг хийж гүйцэтгэсэн ажлын дагуу өдөр тутам хөтөлж, цаашид хийх ажлаа төлөвлөн тэмдэглэн дүгнэж байгаа. Энэ дэвтэр тайлангаа бичихэд багш хөгжлийн дэвтрээ харж байгаад бичлээ. Хийсэн ажлын өдөр хоног алдалгүй тэмдэглэж байсан нь ажлын үр дүнгээ бичихэд дөхөм байсан. Ажилласан хугацаандаа багшийн хөгжлийн дэвтрийн үзүүлэлт бүрээр, өдөр тутам хийх ажил болон хийгдсэн хамрагдсан ажлаа дэлгэрэнгүй бичиж сургалтын албаар дүгнүүлж байсан.

7. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил

- Хичээл бүрийг бэлдэн цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын үйл ажиллагааг тогтмол орж байсан. Мүүдл цахим системийг ашиглан сурагчдаар хичээлээ бэлтгэн зааж байсан.
- НБГ-ийн улсын шалгалтын даалгаврын сангийн нийт 600 даалгавруудыг ажиллуулсан.

8. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

- 9-р ангид Байгалийн ухааны хичээлээр Улсын шалгалтанд бэлтгэх зорилгоор химийн хичээлийг "Эртэч хүүхэд-2" аяны хүрээнд таван удаагийн давтлагыг орсон.
- Химийн хичээлд сонирхолтой болгох, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хичээлийг үр дүнтэй явуулахад анхаарч цахим хэрэглэгдэхүүн, урвалын тэгшитгэл бичих, химийн тооцоот бодлого бодох, тал дээр анхаарч ажиллаж байна.

III. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

1. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа /танхим ба танхимын бус/
2. Ангийн номын сангийн баяжилт
3. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх
4. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал

Эх дэлхийн өдөр, Усны нөөцийг хамгаалах сэдвийн хүрээнд бүтээлийн үзэсгэлэн гаргасан.

5. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль/

- Сургуулийн 7-р ангиудын дунд зохион байгуулсан "Химийн цагаан толгой" уралдааны зохион байгуулалтанд оролцож дүгнэсэн.

6. Олимпиад уралдаан тэмцээн

- ЧД-ийн химийн олимпиадад 9в ангийн сурагч Б.Оюуноминг бэлтгэн оролцуулж 4-р байр эзэлсэн.

7. Бүтээлч ажил

- 10, 11 ангийн сурагчдаар химийн хичээлээр бие даалган PPT бэлдэн цахим хэрэглэгдэхүүнтэй харьцаж бусдадаа хийсэн ажлаа маш сайн танилцуулж, илтгэх чадвар нь сайжирсан.

8. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал

- 9в, 9г, 9е ангиудаас "Сурах хэв шинж"-ийн 30 асуулга бүхий судалгааг нийт 145 сурагчдаас авч нэгтгэн сургалтандаа ашиглаж байна.

9. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- MOODLE цахим системий 5 удаагийн сургалтанд хамрагдаж ,амжилттай шалгагдан сургалтандаа ашиглаж байгаа.
- Олимпиад уралдаанд сурагчаа бэлдэн, өөрөө бодлого бодож мэргэжлийн чадвараа дээшлүүлсэн.
- БУЗАН-ы багш нар болон химийн секцийн багш нартайгаа хамтран ажиллаж судалгаат хичээлийг явуулахад хамтран ажилласан.

I. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт

- Цаг ашиглалтын хуваарийг гарган мөрдөж ажилласан. Сургалтын үйл ажиллагааг явуулах болон ажлын цагийг хоцрох, таслах зөрчил гаргаагүй.
- Журнал болон багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт хийх, хичээл заах
- Цаг үеийн хурал цуглаан, цэнэглэх цагт суух, хяналтын ажил засах
- Дэвтэр засалт, гэрийн даалгаврыг нэг бүрчлэн шалгах
- Мүүдлийн сургалтанд хамрагдах
- Жижүүр багш хийх, ЗАН-ийн хурал болон цаг үеийн ажилд хамрагдах
- Нэгжийн болон улирлын шалгалт авч засах
- Шалгалтын комисс Анги дэвших болон Улсын шалгалтыг авч, засаж, дүнг нэгтгэх
- Хичээлийн дүн оруулах

2. Сэтгэл ханамжийн судалгаа

3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минутийг алдагдалгүй ашиглаж сургалтын үйл ажиллагааг явуулдаг. Ажлын цагийн хоцрогдол, таслалт байхгүй болно.

4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлтийг чандлан мөрдөж алдаа дутагдал гаргаагүй бөгөөд эцэг эх, суралцагч, мэргэжлийн багш нараас санал гомдол ирээгүй болно.

5. Багшийн хичээлийн бэлтгэлийг хийж MOODLE системд хичээлээ байршуулах, шалгалтыг авах, гэрийн даалгаврыг хийхэд тогтмол ашиглахад суралцаж байна.

6. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн
Тухайн хичээлд ирээгүй сурагчдыг ангийн багшаас тодруулж асуух учир шалтгааныг тодруулах, хичээлийг нөхөн суралцах боломжийг олгодог.

7. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал

Багшийн журналыг Багшийн бичиг баримт хөтлөх журмын дагуу хөтөлдөг.

8. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал

Газарзүйн хичээл нь хүрээлэн буй орчин, үзэгдэл юмсын зүй тогтол хамаарлыг судалдаг тул цахим хэрэглэгэдхүүн , видео бичлэг үзүүлэх шаардлагатай байдаг тул тогтмол ашигладаг.

Нэгжийн төлөвлөлт	Тестийн сангийн тоо		Хэрэглэгдэхүүний тоо				Хүүхдийн хөгжлийг дэмжсэн ажил		Нээлттэй хичээл	Ур чадварын уралдаанд оролцсон
	Шинээр боловсруулсан	Бэлэн даалгавар ашигласан	Видео	Цахим, биет зураг	РРТ	бусад	Хамтарсан	Бие дааж		
	12	24	8	20	34	2	3	1		

9. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт

10. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал

II. Эрүүл мэнд

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон эерэг харилцааг хэвшүүлэх

2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

4-р цагийн гимнастикийг хийхэд анхаарч 9е, 11д ангиудын сурагчидтай хамтран хийдэг.

3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн- 11-р ангийн сурагчдад усыг зөв зохистой ашиглах, гамнах , хэрэглээгээ зохицуулах талаар сургалт орж 2070 оноос ирсэн захидал бичлэгийг үзүүлэн хэлэлцүүлэг явуулан УС сэдвийн хүрээнд зохион бичлэг хийх бүтээлч даалгаврыг хийсэн. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хичээлээр үр хөндөлтийн хор уршгийн талаар сургалт хийсэн.

4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал- Хичээл орж буй ангиудад хог хаягдалаа авах, ширээгээ тэгшилж суух, агааржуулалт тогтмол хийх зэрэгт хичээл эхлэхийн өмнө анхааруулан хэвшүүлэхэд анхаарч байна.

5. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал

8-р ангийн сурагчдын дунд агаар, ус, хөрсний бохирдол түүнээс сэргийлэх арга замын талаар цахим хичээл орж, байгал дэлхийгээ хайрлах энэрэх сэтгэлийг төлөвшүүлж байна.




6. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх

Хичээл сургалтын үйл ажиллагааны дараа ангийн жижүүр сурагчаар самбарыг заавал арчуулан дараагийн багш хичээл ороход бэлэн болгодог.

7. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
8. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал
9. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
10. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил

Хавсралт:

Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт-Багшийнхөгжлийн дэвтрийн хөтлөлт



БМДИ 5дахь жилийн үндсэн сургалтад хамрагдсан байдал:





Мүүдл сургалт



Олимпиад, уралдаан тэмцээн



Сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал:



Хэлний баяраар:

Герман хэлний үзэсгэлэнгийн самбарын эх бэлтгэж үзэсгэлэн гаргахад туслав.



Вакцинжуулалтанд ажиллав.

